



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй  
үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Лэндмн ББСБ” ХХК нь нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан тус компанийн нэг бүр нь 10 /арав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 800,000,000 /найман зуун сая/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Лэндмн ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 10 /арав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 600,000,000 /зургаан зуун сая/ ширхэг хувьцааг өмчлөх эрхийг “Анд Системс” ХХК-ийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 100,000,000 /нэг зуун сая/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 25 /хорин тав/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Лэндмн ББСБ” ХХК /М.Түвшинжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 100,000,000 /нэг зуун сая/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийн үнийг 25 /хорин тав/ төгрөгөөр “Лэндмн ББСБ” ХХК-ийн тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид худалдахыг зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тогтоолын 3, 4-т заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааны 80 /ная/ ба түүнээс дээш хувийг хуанлийн 30 хоногийн дотор анхдагч зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцох бөгөөд худалдагдаагүй үлдсэн хэсгийг хүчингүйд тооцохыг “Лэндмн ББСБ” ХХК /М.Түвшинжаргал/-д мэдэгдсүгэй.

6. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 5-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд “Мирэ эссет секьюритис Монгол ҮЦК” ХХК /Н.Цэвэгмид/-д хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг мэдэгдсүгэй.

8. “Лэндмн ББСБ” ХХК нь компанийн хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Лэндмн ББСБ” ХХК /М.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.

9. Үнэт цаасны танилцуулга холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Мирэ эссет секьюритис Монгол ҮЦК” ХХК /Н.Цэвэгмид/, “ЭмДиЭс энд Хаанлекс” ХХН /Ж.Майзориг/, “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК /Петр Марки/, “Гэрэгэ Эстимэйт” ХХК /Д.Ганбаатар/-д тус тус анхааруулсугай.

10. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН